ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2025 оны санхүүгийн хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/139/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Алтан-Тосон аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: altantosonaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс:7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.12 № 17

...-ний ... -ны № ... -т

УЛИАСТАЙ СУМЫН
ДЭВШИЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.МӨНХДЭЛГЭР-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургууль нь нөхөн хангалтын зардлаас 47,901,700 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч бүртгэлд тусгасан, Монголын цахилгаан холбооны утасгүй интернэтийн төлбөрийн үлдэгдэл 24,626,600 төгрөгийн өглөгийг төлж барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны зардлыг давхардуулан олгосон, сургуулийн захирал, менежерт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал илүү олгосон, үйлчлэгч, сантехникч нарт хууль, журамд заагаагүй бохирын нэмэгдэл 10 хувиар тооцож олгосон, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан багш ажилчдын байгууллагаас олгох үзлэг, шинжилгээний төлбөрийг илүү шилжүүлсэн, багш хөгжлийн бүлгийн чиглүүлэгч 3 багшид нэмэгдэл хөлсийг олгохдоо хийсэн ажлын тайлан, гарсан үр дүнг тооцоогүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх

D:\Албан бичиг\А4-2026.docx

8126051

үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох үндсэн цалингийн нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй олгосон зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургууль нь аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Эрдэмтэн сурагчдын хөгжлийн институт, "Дижитал плас эй ай ирээдүйн" төв, Монголын хүний нөөц удирдлага шинэчлэлийн хүрээлэн, Хөгжил шинэчлэл сургалтын мэргэшсэн нийгэмлэг болон бусад чиглэлээр математик, мэдээлэл технологи, судлагдахуйн сургалтуудыг авч, нийт 12,121,800 төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *|төгрөгөөр|*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 333,434,284.66 | 242,945,189.43 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 217,488,975.96 | 50,634,687.33 |
| 4 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 217,488,975.96 | 50,634,687.33 |
| 5 | Төгрөг | 217,488,975.96 | 50,634,687.33 |
| 6 | Төрийн сангийн харилцах | 217,488,975.96 | 50,634,687.33 |
| 8 | АВЛАГА | 82,926.00 | |
| 9 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 82,926.00 | |
| 13 | БАРАА МАТЕРИАЛ | 115,862,382.70 | 192,310,502.10 |
| 14 | Хангамжийн материал | 115,336,002.70 | 192,036,402.10 |
| 15 | Хүнсний материал | 4,687,400.00 | |
| 16 | Бусад хангамжийн материал | 61,235,243.70 | 179,368,423.10 |
| 18 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 333,434,284.66 | 242,945,189.43 |
| 20 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,155,635,659.71 | 2,085,581,302.43 |
| 21 | Биет хөрөнгө | 2,055,520,784.71 | 1,985,638,302.43 |
| 22 | Барилга, байгууламж, орон сууц | 1,863,985,492.00 | 1,854,685,492.00 |
| 23 | Хуримтлагдсан элэгдэл | -202,394,206.32 | -268,296,898.68 |
| 26 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 345,994,592.31 | 485,768,495.69 |
| 27 | Хуримтлагдсан элэгдэл | -160,417,882.70 | -242,819,610.38 |
| 28 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 285,943,762.25 | 235,700,626.72 |
| 29 | Хуримтлагдсан элэгдэл | -117,280,425.83 | -131,759,599.92 |
| 32 | Ном | 39,689,453.00 | 52,359,797.00 |
| 33 | Биет бус хөрөнгө | 100,114,875.00 | 99,943,000.00 |
| 34 | Програм хангамж | 2,530,000.00 | |
| 35 | Хуримтлагдсан элэгдэл | -2,358,125.00 | |
| 36 | Бусад биет бус хөрөнгө | 99,943,000.00 | 99,943,000.00 |
| 37 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,155,635,659.71 | 2,085,581,302.43 |
| 38 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,489,069,944.37 | 2,328,526,491.86 |
| 39 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 84,858,900.00 | 47,638494.30 |
| 40 | Өглөг | 84,858,900.00 | 47,638494.30 |
| 41 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 84,858,900.00 | 5,139,994.30 |
| 42 | Бусад өглөг | | 42,498,500.00 |
| 43 | Байгууллагад төлөх өглөг | 84,858,900.00 | 42,498,500.00 |
| 47 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 84,858,900.00 | 47,638494.30 |
| 48 | Засгийн газрын хувь оролцоо | 2,489,069,944.37 | 904,125,436.71 |
| 49 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 744,596,274.90 | 744,596,274.90 |
| 53 | Хуримтлагдсан үр дүн | 1,344,610,682.13 | 1,031,129,802.89 |
| 54 | Өмнөх үеийн үр дүн | 1,344,610,682.13 | 1,344,610,682.13 |
| 55 | Тайлант үеийн үр дүн | | -313,480,879.24 |
| 56 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 455,696,338.64 | 505,161,919.77 |
| 57 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,544,903,295.67 | 2,280,887,997.56 |
| 58 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,629,762,195.67 | 2,328,526,491.86 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,008,197,400.00 | 3,329,959,752.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,673,392,700.00 | 2,998,012,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,673,392,700.00 | 2,998,012,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 334,804,700.00 | 331,947,452.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 334,804,700.00 | 331,947,452.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 90,050,904.10 | 126,014,213.35 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 90,050,904.10 | 126,014,213.35 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 17,827,400.00 | 59,903,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,153,400.00 | 50,529,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,674,000.00 | 9,374,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 49,144,695.00 | 39,601,221.05 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 23,078,809.10 | 26,509,392.30 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,008.197,400.00 | 3,455,973,965.35 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,053,885,165.30 | 3,752,659,528.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,053,885,165.30 | 3,556,897,708.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,994,700,715.96 | 2,549,224,787.88 |
| 210101 | Үндсэн цалин | 1,287,776,672.56 | 1,500,583,014.91 |
| 210102 | Нэмэгдэл | 624,885,003.40 | 822,503,282.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 81,355,000.00 |
| 210104 | Урамшуулал | 82,039,040.00 | 144,763,490.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 247,552,545.38 | 316,923,606.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 170,673,224.33 | 217,945,700.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,031,528.43 | 25,640,670.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,962,964.45 | 13,032,238.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,376,565.74 | 11,989,112.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,506,262.43 | 48,315,884.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 329,803,931.33 | 331,254,146.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,362,811.33 | 19,990,296.30 |
| 210302 | Түлш, халаалт | 291,573,100.00 | 282,024,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,868,020.00 | 29,239,210.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,923400.00 | 5,833,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,923400.00 | 5,833,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,813,613.16 | 48,037,827.68 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,500,000.00 | 7,673,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,313,613.16 | 40,364,527.68 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 321,327,834.80 | 305,624,040.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 124,458,158.16 | 111,306,331.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,187,435.20 | 18,059,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 171,682,241.44 | 176,258,509.76 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 131,763,124.67 | 195,761,820.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 131,763,124.67 | 195,761,820.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 131,763,124.67 | 195,761,820.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 768.67 | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,053,885,165.30 | 3,752,659,528.83 |

| | | | |
|---|---|---|---|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 44,363,138.80 | -296,685,563.48 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 4,489,656.40 | 16,795,315.76 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 4,489,656.40 | 16,795,315.76 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -4,489,656.40 | -16,795,315.76 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 39,873,482.40 | -313,480,879.24 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,026,024,800.00 | 3,389,863,352.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 17,827,400.00 | 59,903,600.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 17,827,400.00 | 59,903,600.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 59,903,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,153,400.00 | 50,529,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,674,000.00 | 9,374,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,008,197,400.00 | 3,329,959,752.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,673,392,700.00 | 2,998,012,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,673,392,700.00 | 2,998,012,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 334,804,700.00 | 331,947,452.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 334,804,700.00 | 331,947,452.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,898,189,574.86** | **3,588,685,165.77** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,898,189,574.86 | 3,588,685,165.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,770,173,850.19 | 3,394,011,345.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,994,816,259.27 | 2,549,224,787.88 |
| 210101 | Үндсэн цалин | 1,287,961,799.07 | 1,508,347,282.58 |
| 210102 | Нэмэгдэл | 624,815,420.20 | 815,124,186.38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 81,351,645.43 |
| 210104 | Урамшуулал | 82,039,040.00 | 144,401,673.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 247,354,076.07 | 316,923,606.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 168,642,733.48 | 218,020,969.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,204,085.53 | 25,640,670.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,049,292.28 | 12,752,471.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,691,212.95 | 12,078,971.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,766,751.83 | 48,430,523.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 329,803,931.33 | 326,114,152.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,362,811.33 | 19,990,296.30 |
| 210302 | Түлш, халаалт | 291,573,100.00 | 282,024,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,868,020.00 | 24,099,215.70 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 5,833,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,833,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,555,938.26 | 65,805,127.68 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,500,000.00 | 7,673,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 41,055,938.26 | 58,313,827.68 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,643,645.26 | 130,110,372.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,474,645.26 | 112,051,172.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,169,000.00 | 18,059,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 128,015,724.67 | 194,673,820.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 128,014,956.00 | 194,673,820.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 128,014,956.00 | 194,673,820.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 127,835,225.14 | -198,821,813.77 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 46,359,700.00 | 48,408,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 46,359,700.00 | 48,408,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 46,359,700.00 | 48,408,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -46,359,700.00 | -48,408,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 81,475,525.14 | -247,229,813.77 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 217,488,975.96 | 298,964,501.10 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 298,964,501.10 | 50,634,687.33 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 744,596,274.90 | 455,696,338.64 | 1,344,610,682.13 | 2,544,903,295.67 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 49,465,581.13 | | 49,465,581.13 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | -313,480,879.24 | -313,480,879.24 |
| 19 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 744,596,274.90 | 505,161,919.77 | 1,031,129,802.89 | 2,280,887,997.56 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 3,389,863,352.00 | 3,389,863,352.00 | | 100 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,998,012,300.00 | 2,998,012,300.00 | | 100 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 331,947,152.00 | 331,947,152.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 331,947,152.00 | 331,947,152.00 | | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 50,529,600.00 | 50,529,600.00 | | 100 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,374,000.00 | 9,374,000.00 | | 100 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,770,760,652.00 | 3,588,685,165.77 | 182,075,486.23 | 95.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,770,760,652.00 | 3,637,093,065.77 | 133,667,486.23 | 96.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,566,580,652.00 | 3,394,011,345.77 | 172,569,306.23 | 95.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,613,286,500.00 | 2,549,224,787.88 | 64,061,712.12 | 97.55 |
| 210101 | Үндсэн цалин | 1,684,168,500.00 | 1,508,347,282.58 | 175,821,217.42 | 89.56 |
| 210102 | Нэмэгдэл | 822.499.200.00 | 815.124.186.38 | 7.375.013.62 | 99.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 81,351,645.43 | -81,351,645.43 | |
| 210104 | Урамшуулал | 106,618,800.00 | 144,401,673.49 | -37,782,873.49 | 135.44 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 327,805,300.00 | 316,923,606.21 | 10,881,693.79 | 96.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 223,092,500.00 | 218,020,969.06 | 5,071,530.94 | 97.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 26,178,300.00 | 25,640,670.78 | 537,629.22 | 97.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,089,100.00 | 12,752,471.72 | 336,628.28 | 97.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,089,100.00 | 12,078,971.21 | 1,010,128.79 | 92.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 52,356,300.00 | 48,430,524.44 | 3,925,776.56 | 92.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 326,114,152.00 | 326,114,152.00 | | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,990,296.30 | 19,990,296.30 | | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 282,024,640.00 | 282,024,640.00 | | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,099,215.70 | 24,099,215.70 | | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,833,300.00 | 5,833,300.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 5,833,300.00 | 5,833,300.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 78,001,500.00 | 65,805,127.68 | 12,196,372.32 | 84.36 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,496,200.00 | 7,673,300.00 | 8,822,900.00 | 46.52 |
| 210808 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 61,505,300.00 | 58,131,827.68 | 3,373,472.32 | 94.52 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215,539,900.00 | 130,110,372.00 | 85,429,528.00 | 60.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 197,479,300.00 | 112,051,172.00 | 85,428,128.00 | 56.74 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,060,600.00 | 18,059,200.00 | 1,400.00 | 99.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 204,180,000.00 | 194,673,820.00 | 9,506,180.00 | 95.34 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 204,180,000.00 | 194,673,820.00 | 9,506,180.00 | 95.34 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 204,180,000.00 | 194,673,820.00 | 9,506,180.00 | 95.34 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,770,760,652.00 | 3,637,093,165.77 | 133,667,486.23 | 96.46 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 298,964,501.10 | - 298,964,501.10 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 50,634,687.33 | -50,634,687.33 | |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 79 | 79 | | 100 |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 64 | 64 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| д/д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 200 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 326,114,152.00 | 326,114,152.00 | | 100.00 |
| 201 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 326,114,152.00 | 326,114,152.00 | | 100.00 |
| 202 | Бараа, үйлчилгээний зардал | 326,114,152.00 | 326,114,152.00 | | 100.00 |
| 215 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 326,114,152.00 | 326,114,152.00 | | 100.00 |
| 216 | Гэрэл цахилгаан | 19,990,296.30 | 19,990,296.30 | 0 | 100.00 |
| 217 | Түлш, халаалт | 282,024,640.00 | 282,024,640.00 | 0 | 100.00 |
| 218 | Цэвэр, бохир ус | 24,099,215.70 | 24,099,215.70 | 0 | 100.00 |
| 232 | Эд хогшил худалдан авах | 5,833,300.00 | 5,833,300.00 | 0 | 100.00 |
| 236 | Урсгал засвар | 5,833,300.00 | 5,833,300.00 | - | 100.00 |
| 1765 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 326,114,152.00 | 326,114,152.00 | - | 100.00 |
| 1771 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 326,114,152.00 | 326,114,152.00 | - | 100.00 |
| 1772 | Орон нутгийн төсвөөс | 326,114,152.00 | 326,114,152.00 | - | 100.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,147.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,815.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,331.6 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж өглөө.

**3.1 Залруулга хийгдээгүй**

**3.2 Төлбөрийн акт:**

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 50,000 төгрөгийн хоолны зардлыг, захирал, сургалтын менежер нарт 2,545,614 төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан багш, ажилчдын төрөөс төлөх шинжилгээний төлбөрт 1,220,000 төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлинй 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.", Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/238, А/340 дүгээр хамтарсан тушаал, Боловсролын сайдын 2024 оны А/279 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.8.2-д "энэхүү журмын 2.6.6-д заасан эрүүл мэндийн багийн тайлан мэдээнд үндэслэн талууд гэрээг дүгнэн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбарийн акт тогтоолоо.

**3.3 Албан шаардлага өгөгдөөгүй**

**3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

***Илрүүлэлт-1:***. Багш хөгжлийн бүлэгт олгосон 2,389.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Багш хөгжлийн бүлгийн болон чиглүүлэгч багш нарт олгосон нэмэгдэл хөлсний нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлэх;

***Илрүүлэлт-2***: Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөөгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцоогүй, хийсэн ажил нь тодорхойгүй, хичээлд суугаагүй тохиолдолуудыг бүртгэн тооцоо хийгээгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, дутуу баримтаар 2,285.3 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг журамд заасны 10 хувиар тооцож олгох, анхан шатны нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлж хэвших;

***Илрүүлэлт-3***: Сургуулийн үйлчлэгч, сантехникчид хууль, журамд заагаагүй бохирын нэмэгдэл 10 хувиар тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийн хүлрээнд зарлага гаргаж, албан хаагчдад хууль, журамд заагаагүй нэмэгдэл хөлс тооцож олгохгүй байх;

Энэхүү , зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## .ДӨРӨВ АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 50,000 төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон. | 1 | 50.0 | 1 | 50.0 | | | | | | | | |
| Сургуулийн захирал, менежерт 2025 оны 10 сард 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,545,614 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. | 1 | 2,545.6 | 1 | 2,545.6 | | | | | | | | |
| Сургуулийн үйлчлэгч, сантехникчид хууль, журамд заагаагүй бохирын нэмэгдэл 10 хувиар олгосон. | 1 | 1,657.0 | | | | | 1 | 1,657.0 | | | | |
| 2025 оны эрүүл мэндийн үзлэгт хамруулсан багш ажилчдын байгууллагаас олгох үзлэг, шинжилгээний төлбөрийг илүү шилжүүлсэн | 1 | 1,220.0 | 1 | 1,220.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй олгосон, хийсэн ажил нь тодорхойгүй, зарим хүүхдүүд хичээл, сургуулиас гарсан, суугаагүй тохиолдолуудыг бүртгэн тооцоо хийгээгүй, хийсэн ажлыг нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна. | 1 | 2,285.4 | | | | | 1 | 2,285.4 | | | | |
| Багш хөгжлийн бүлгийн чиглүүлэгч 3 багшид 2,389,240 төгрөгийн нэмэгдэл хөлсийг хийсэн ажлын тайлан, гарсан үр дүнг тооцож олгоогүй, нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна. | 1 | 2,389.2 | | | | | 1 | 2,389.2 | | | | |
| **Дүн** | **6** | **10,147.2** | **3** | **3,815.6** | | | **3** | **6,331.6** | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | **1** | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2026-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

"АЛТАН ТОСОН АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР Ж.ТУНГАЛАГ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2026-02-24